



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дархан-Уул аймгийн Хонгор сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДАА-2022/66-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
Дархан-Уул аймаг
2022 он

Тэргүүлэх аудиторын албан үүргийг
түр орлон гүйцэтгэгч: Ш.Мөнхбаяр
Утас: 7037-3089
Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn
Ахлах аудитор: С.Батцэцэг
Утас: 7037-3089
Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn
Аудитор: Л.Дамдинжав
Утас: 70376994
Цахим хаяг: dalaivandarkhan@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна



**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

45089 Дархан-Уул аймаг,
Дархан сум, 14-р баг
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089
E-mail: darhanuul@audit.gov.mn

**ХОНГОР СУМЫН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ДАРГА
Н.ГАНБААТАР ТАНАА**

2022.02.25 № 175
Танай _____ -ны № _____ -т



Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 20 дугаар зүйлийн 20.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хонгор сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Хонгор сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн зөв, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайланг материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Хонгор сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус салбарт мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн шууд захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Ш.МӨНХБАЯР

00900165

Нэг. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

/сая төгрөгөөр/

	Үзүүлэлт	2020.12.31	2021.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	4.48	6.93
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	28.28	34.66
	Нийт хөрөнгийн дүн	32.75	41.59
	Нийт өр төлбөрийн дүн	4.62	-
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	28.14	41.59
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	32.75	41.59
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	106.43	118.19
	Үйл ажиллагааны зардлын дүн	112.23	104.74
	Үйл ажиллагааны үр дүн	(5.79)	13.45
	Үйл ажиллагааны бус үр дүн	-	-
	Үйл ажиллагааны нийт үр дүн	(5.79)	13.45
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	24.56	18.77
	Тайлант оны үр дүн	(5.79)	13.45
	Эцсийн үлдэгдэл	18.77	32.22
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	106.27	118.19
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	106.27	107.69
	Үйл ажиллагааны ЦМГ	-	10.50
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	-	(10.50)
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	-
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	115.96	113.18
	Урсгал зардал	115.96	113.18
	Хөрөнгийн зардал	-	-
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	115.96	113.18
	Улсын төсвөөс санхүүжих	-	-
	Орон нутгийн төсвөөс санхүүжих	115.96	113.18
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	-	-

Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Хонгор сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал нь “Нутгийн өөрөө удирдах ёсыг төлөвшүүлэн нутгийн удирдлагын нэгдмэл байдлыг хангаж, иргэдийн идэвх оролцоонд тулгуурлан, орон нутгийн хөгжлийн бодлого, чиг хандлагыг оновчтой тодорхойлох, эдийн засаг нийгмийн асуудлыг бие даан шийдвэрлэхэд оршино” гэсэн зорилт тавин ажиллаж байна.

Гурав. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Үндсэн хөрөнгийн ангилалд ашиглаж байгаа боловч үлдэх өртөг нь “0” үлдэгдэлтэй болсон 10,892.6 мянган төгрөгийн анхны өртөгтэй, 11 нэр төрлийн хөрөнгүүдийг ашиглаж байгаа нь УСНББОУС-17 “Үндсэн хөрөнгө”-ийн 49 дэх “... дахин үнэлэгдсэн хөрөнгийн бодит үнэ цэнэ нь дансны үнээсээ материаллаг ялгаатай байвал цаашид дахин үнэлэх зайлшгүй шаардлагатай” гэсэн заалттай нийцэхгүй байна. Иймд “0” үлдэгдэлтэй хөрөнгийг цаашид ашиглах бол дахин үнэлэх эсвэл акталж устгах асуудлыг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд тавьж шийдвэрлүүлэх шаардлагатай байна, албан тушаалтанд тавьж шийдвэрлүүлэх шаардлагатай байна.

Дөрөв. Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

Тав. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Тайлант хугацаанд шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 149 мэдээллээс хугацаанд нь 145 мэдээллийг бүрэн оруулсан, 1 мэдээллийг байршуулах хугацаа болоогүй, 3 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Зургаа. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй болно.

Долоо. Аудитын илрүүлэлт:

Аудитаар илэрсэн алдаа зөрчлийг арилгах давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө.

7.1 Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо		Санал дүгнэлтийн хэлбэр
		Аудит ад хамр агдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр	

			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй	Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс тагталзсан
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
НИЙТ									

7.2 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

/сая төгрөгөөр/

№	Төсвийн захирагчийн ангилал	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
A	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
1	ТШЗ	1								1	
2	Төсөл, хөтөлбөр										
3	ЗГТС										
4	ТТЗ										
5	ТЕЗ										
НИЙТ		1								1	